



**МОНГОЛ УЛСЫН
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД**

Засгийн газрын IX байр, Энхтайвны өргөн чөлөө 16а,
Баянзүрх дүүрэг, Улаанбаатар хот, 13381
Утас: 26 22 71, Факс: (976-51) 26 32 37,
Цахим шуудан: mofa@mofa.gov.mn,
Цахим хуудас: www.mofa.gov.mn


2026.07.09 № 01/2417

танай _____-ны № _____-т

**УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Б.УЯНГА ТАНАА**

Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний экспорт,
тулгамдаж буй асуудлын талаар ирүүлсэн асуулгын
хариултыг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 26 хуудастай.



Ц.ИДЭРБАТ

1301041316

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн
үйлдвэрийн сайдын 2026 оны 07 дугаар
сарын 09-ний өдрийн 01/24/27 тоот
албан бичгийн хавсралт.

Асуулга-1: Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний экспортын хэмжээ, бүтэц, экспортын орлого, гол нэр төрлийн бүтээгдэхүүн, сүүлийн 10 жилд аж ахуй нэгжид олгосон зөвшөөрлийн сүүлийн 10 жилийн статистик мэдээлэл;

Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний экспорт

Монгол Улсын хөдөө аж ахуйн экспортын бүтэц нь ихэвчлэн мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн давамгайлсан, түүхий эд, хагас боловсруулсан болон бэлэн бүтээгдэхүүн хэлбэрээр экспортолдог. Хөдөө аж ахуйн экспортын 80 орчим хувийг мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн, үлдсэн хувийг ургамлын гаралтай бүтээгдэхүүн эзэлдэг.

Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний экспортын бүтцийг авч үзвэл Малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний экспортод амьд мал, мах, дайвар бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүн, шувууны өндөг, зөгийн цэвэр бал зэрэг ордог бол ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний экспортод үр тариа, хүнсний ногоо, төмс, тосны ургамал, жимс, самар зэрэг ордог.

Гаалийн ерөнхий газрын мэдээллээр 2016–2018 онд хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний экспорт тогтвортой өсөж, экспортын орлого 64.3 сая ам.доллараас 124.6 сая ам.долларт хүрсэн байна. Коронавируст цар тахлын улмаас 2019 оноос экспортын тоо хэмжээ буурч 2020 онд нийт экспортын орлого 64.6 сая ам.доллар болж буурч байсан.

Харин 2021–2023 онд Монгол Улсын хөдөө аж ахуйн (ХАА) бүтээгдэхүүний экспортын орлого түүхэн дээд хэмжээнд буюу 364.0 сая ам.долларт хүрсэн нь цар тахлын дараах эдийн засгийн сэргэлт, мөн төрөөс хэрэгжүүлсэн хэд хэдэн томоохон бодлого, зохицуулалтын арга хэмжээнүүдтэй шууд холбоотой. Тухайлбал, Засгийн газраас 2021 онд Ковид-19 цар тахлын эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-ний хүрээнд жижиг, дунд үйлдвэрлэл болон ХАА-н салбарт ажлын байрыг хадгалах, дотоодын үйлдвэрлэлийг үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах чиглэлээр хөрөнгө оруулалтын дэмжлэгүүд нь 2023 онд үр дүнгээ өгч, салбарын экспорт дээд цэгтээ хүрэх суурь болсон.

2023-2024 оны өвөл Монгол оронд зудын гамшиг нүүрэлсэний улмаас сая сая мал хорогдсон нь түүхий эдийн (мах, ноос, ноолуур, арьс шир) бэлтгэл шууд тасалдах гол шалтгаан болж, 2024 оны хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний экспорт 33.3 хувиар огцом буурсан.

2024 оны зудын гамшгийн дараа буюу 2025 онд салбарын дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) 5.6%-ийн өсөлт үзүүлж, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний экспортын орлого 321.1 сая ам. долларт хүрч, өмнөх оноос 14.9 хувиар өссөн. Энэхүү богино хугацааны сэргэлт болон экспортын өсөлтөд Ерөнхийлөгчийн санаачилсан “Хүнсний хувьсгал” болон “Цагаан алт” үндэсний хөтөлбөрүүд голлох нөлөө үзүүлсэн.

Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний экспорт 2025 оны байдлаар 321.1 мянган ам.доллар байсан бол үүнээс Мал, амьтан тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүн 250.1 мянган ам.доллар, Ургамлын гаралтай бүтээгдэхүүн 66.1 мянган ам.доллар, Мал, амьтан, ургамлын гаралтай өөх тос 4.9 мянган ам.доллар байсан. Харин 2026 оны эхний 5 сарын байдлаар 105.8 мянган ам.доллар байна. *(Хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний экспортын 2015-2026 оны статистик мэдээг хүснэгт 1-д харуулав.)*

Гол нэр төрлийн бүтээгдэхүүний хувьд экспортод гаргасан малын мах биет хэмжээгээр 2024 онд 47.7 мянган тонн байсан бол 2025 онд 57.5 мянган тоннд хүрч, өмнөх оноос 9.8 (20.6%) мянган тонноор, үнийн дүн 215.9 сая ам.долларт хүрч, 41.3 (23.6%) сая ам.доллараар тус тус өссөн байна. Махны экспортод адууны мах голлож, 2025 онд экспортолсон нийт малын махны үнийн дүнгийн 57.6 хувийг эзэлж байна. Адууны махны 88.7 хувийг БНХАУ, 9.0 хувийг Казахстан, 1.8 хувийг Узбекистан, 0.6 хувийг бусад улсад тус тус экспортолжээ. Самнасан ноолуурын экспортын хэмжээ 2025 онд 4.0 мянган тонн болж, өмнөх оноос 3.3 (5.7 дахин) мянган тонноор, үнийн дүн 332.5 сая ам.доллар болж, 262.6 (4.8 дахин) сая ам.доллараар тус тус өсжээ. Самнасан ноолуурын 82.3 хувийг БНХАУ, 13.7 хувийг Итали улсад, 2.5 хувийг Их Британи улсад, 1.5 хувийг бусад улсад экспортолсон байна. Угаасан болон самнасан ноолуур, хонины ноос нь нийт экспортын 2.2 хувийг бүрдүүлж байна. *(Зарим гол нэр төрлийн бүтээгдэхүүний экспортын хэмжээ, үнийн дүн 2015-2025 оны статистик мэдээг хүснэгт 2 болон хүснэгт 3-д харуулав.)*

Амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний экспортын зөвшөөрөл олгох хүрээнд: Монгол Улсын Амьтан ургамал тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт шалгалтын тухай хууль болон холбогдох бусад хуульд өөрчлөлт орж Мал эмнэлгийн ерөнхий газраас 2025 оны 2 дугаар сарын 20-ны өдрөөс мал амьтан тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнд олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ буюу энгийн зөвшөөрлийн хүсэлтийг гадаад худалдаа эрхлэгчдийн үйл ажиллгааг хөнгөвчлөх, төрийн үйлчилгээг шуурхай хүргэх, ил тод нээлттэй байдлыг хангах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний экспортын нэг цонхны цахим систем /export.mofa.gov.mn/-ээр хүлээн авч шийдвэрлэн олгож байна. Энэ хүрээнд: 2025 онд иргэн, аж ахуйн нэгжид 7350 олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ, 2026 онд иргэн аж ахуйн нэгжид 2201 олон улсын мал эмнэлгийн гэрчилгээг тус тус олгосон.

Ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний экспортын зөвшөөрөл олгох хүрээнд: “Амьтан, ургамал тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт шалгалтын тухай”, Ургамлын эрүүл мэнд, ургамал

хамгааллын тухай”, “Хүнсний тухай”, “Байгалийн ургамлын тухай”, “Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын тухай” хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг үндэслэн “Ургамлын хорио цээрийн гэрчилгээ”, “Импортын мэдэгдэл”, “Дамжуулан тээвэрлэх мэдэгдэл”-ийн хүсэлтийг гадаад худалдаа эрхлэгчдийн үйл ажиллагааг хөнгөвчлөх, төрийн үйлчилгээг шуурхай хүргэх, ил тод нээлттэй байдлыг хангах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний экспортын нэг цонхны цахим систем /export.mofa.gov.mn/-ээр хүлээн авч шийдвэрлэн олгож байна.

Хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх эрсдэлийн түвшинг харгалзан ургамал, тэдгээрийн гаралтай бараанд импортын мэдэгдэл олгох жагсаалтыг ХХААХҮСайдын 2025 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн А161 дүгээр тушаалаар батлуулсанаар ургамлын хөнөөлт организмыг хадгалах, тээвэрлэх эрсдэл бүхий нийт 376 ургамал, ургамлын гаралтай бүтээгдэхүүнд импортын мэдэгдэл олгох эрх зүйн орчин бүрдсэн.

“Ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд ургамлын хорио цээрийн гэрчилгээ, импортын болон дамжин өнгөрүүлэх мэдэгдлийн хүсэлтийг цахимаар хүлээн авах, хянах, шийдвэрлэх” журамыг Ургамал хамгааллын газрын даргын 2025 А/45 тушаалаар батлуулан үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна. Энэ хүрээнд: 2025 онд 557 иргэн, аж ахуй нэгжид 2142 ургамлын хорио цээрийн гэрчилгээ, 2026 онд 245 аж ахуй нэгжид 336 ургамлын хорио цээрийн гэрчилгээг тус тус олгосон.

Тус яамнаас Зөвшөөрлийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасны дагуу тусгай зөвшөөрлийг иргэн, аж ахуй нэгжид license.mofa.gov.mn цахим системээр хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэн олгож байна. Экспортын хувьд “Мал, малын үржүүлгийн бүтээгдэхүүн гадаадад гаргах” тусгай зөвшөөрлийг олгож байна.

(ХХААХҮЯ-наас шинээр олгосон болон сунгалт хийсэн тусгай зөвшөөрлийн мэдээллийг хүснэгт 4-д харуулав.)

Асуулт-2: Мах, сүү, сүүн бүтээгдэхүүн, ноос, ноолуур, арьс шир, газар тариалангийн бүтээгдэхүүний экспортод голлох байр суурь эзэлж байгаа улсуудын талаарх судалгааны мэдээлэл;

Монгол Улсаас БНХАУ, ОХУ, Солонгос, Казакстан, Вьетнам, Япон, Хонконг, Катар, Ирак, Таджикистан, Кувейт, Арабын Нэгдсэн Эмират, Азарбайжан, Турк, Узбекистан, Туркменистан, Тажикистан, Азербайджан, Иран, БНАСАУ, Бахрайн зэрэг 19 улс оронд мал амьтан тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүн экспортлогдож байна.

Монгол Улсаас экспортлож буй мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний экспортын зах зээлийг дараах байдлаар нэгтгэн харуулж болно. /2025 оны байдлаар/

Бүтээгдэхүүн	Гол импортлогч улсууд
Мах	БНХАУ-62%, Булангийн орнууд-22%, бусад орнууд-16%
Сүү, сүүн бүтээгдэхүүн	Киргизстан-86.7%, АНУ-6.4%, БНХАУ-3.7%, Япон-3.3%

Ноос	БНХАУ-80.1%, Япон-8.2%, Непал-5.1%, БНСУ-3.7%
Ноолуур	БНХАУ-82.7%, Итали-13.3%, Их Британи-2.5%, Франц-0.7%
Арьс шир	БНХАУ-70.0%, Турк-19.4%, АНУ-6.32%, БНСУ-2.7%

Монгол Улсын газар тариалангийн салбарын экспорт нь мал аж ахуйн бүтээгдэхүүнтэй харьцуулахад бага хэмжээтэй боловч улаанбуудай, гурил, төмс, хүнсний ногоо, тосны ургамал (рапс), малын тэжээл, органик тариалангийн бүтээгдэхүүн зэрэг бүтээгдэхүүнээр хөгжиж байна. Экспортын гол зах зээл нь хөрш болон бүс нутгийн орнууд байдаг. /2025 оны байдлаар/

Бүтээгдэхүүн	Гол импортлогч орнууд
Рапс (тосны ургамал)	БНХАУ-100%
Гурил /бусад үр тарианы гурил/	БНХАУ-76.5%, Япон-23.0%, АНУ-0.5%
Төмс	Узбекистан-70.5%, Казахстан-28.3%, Киргизстан-1.1%
Малын тэжээлийн ургамал	БНХАУ-100%

(Мах, сүү, сүүн бүтээгдэхүүн, ноос, ноолуур, газар тариалангийн бүтээгдэхүүний экспортын мэдээг 2025 оны эцсийн байдлаар орноор гарган хүснэгт 5-д харуулав.)

Гаалийн байгууллагын мэдээллийн системд бүртгэгдсэн мэдээлэлд үндэслэн сүүлийн 10 жилийн хугацаанд экспортолсон ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний мэдээллийг бэлтгэн хүргүүлж байна. Үүнд: 2016 оны 1 дүгээр сарын 5-наас 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хооронд 50 улсад нийт 833,398.2 тонн ургамлын гаралтай бүтээгдэхүүн, 5559 ширхэг монгол гэр экспортолсон бөгөөд энэ хугацаанд 114 төрлийн HS код бүхий 1,694 төрлийн бараа, бүтээгдэхүүн 40 улсын зах зээлд 16 хилийн боомтоор экспортлогджээ.

Асуулт-3: Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн экспортлоход тулгарч буй мал эмнэлэг, хорио цээр, лабораторийн шинжилгээ, олон улсын стандарт, тээвэр логистикийн хүндрэл зэрэг асуудлаар хийсэн судалгаа, үнэлгээний талаарх мэдээлэл;

Олон улсын байгууллагуудын мал эмнэлэг, хорио цээрийн талаар судалсан судалгааны тоймыг дараах хэсэгт эх сурвалжийн хамт дурдлаа.

НҮБ-ын ХХААБ-ын Монгол улсад “Малын эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдлын тогтолцоог бэхжүүлэх” төслийн үнэлгээнд мал эмнэлгийн тогтолцоо, лабораторийн чадавх, өвчний хяналт, экспортын бэлэн байдлыг үнэлсэн хамгийн ойрын хугацааны FAO үнэлгээний тайлан юм. Тайланд лабораторийн шинэчлэл, өвчний хяналт, мал эмнэлгийн үйлчилгээний чадавхад тулгарсан санхүүгийн болон институцийн хүндрэлүүдийг авч үзсэн. Төслийн тайланг дараах линкээс авч үзнэ үү. <https://openknowledge.fao.org/items/a56076b3-338f-4566-8813-177be2c3bf87>

Мөн НҮБ-ын ХХААБ-ын “Монголын малын эрүүл мэнд, мал эмнэлгийн үйлчилгээний дэмжлэг” төслийн тайланд малын өвчин нь экспорт, худалдааны хамгийн том саад болохыг

тодорхой дурдсан бөгөөд олон улсын эрүүл ахуйн стандарт мөрдөх шаардлага, хорио цээр, баталгаажуулалт, мал эмнэлгийн үйлчилгээний хүчин чадлын асуудлыг тайлбарласан. Төслийн тайланг дараах линкээс авч үзнэ үү. <https://openknowledge.fao.org/server/api/core/bitstreams/4f15a464-63cd-4f94-bdb7-86b4dc5cb243/content>

Дэлхийн Банкны хэрэгжүүлсэн төслүүдийн үнэлгээнд: Малын эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх шаардлагатай, Малын бүртгэл, мөрдөн мөшгөх (traceability) систем хангалтгүй, Малчдаас үйлдвэр хүртэлх нийлүүлэлтийн сүлжээн дэх дамжлаг, тасалдал нь экспортын шаардлага хангахад хүндрэл учруулдаг гэж тэмдэглэсэн. Тайланг дараах линкээс авч үзнэ үү. <https://www.worldbank.org/en/results/2020/11/30/bringing-herders-closer-to-markets-and-livestock-services>

Лаборатор, шинжилгээний асуудал: Экспортын бүтээгдэхүүнд мал эмнэлгийн лабораторын оношилгоо, үлдэгдэл бодисын шинжилгээ, микробиологийн шинжилгээ, хүнсний аюулгүй байдлын сорилт зэрэг олон төрлийн лабораторийн баталгаажуулалт шаардагддаг. Олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн лабораторийн чадавх, магадлан итгэмжлэл, шинжилгээний харилцан хүлээн зөвшөөрөл хангалтгүй байгаа нь экспортын өртгийг өсгөдөг гэж НҮБ-ын ХХААБ-ын судалгаанд үнэлэгдсэн. <https://www.fao.org/mongolia/resources/publications/en>

Олон улсын стандартын шаардлага хувьд НҮБ-ын ХХААБ-ын судалгааны дүгнэлтээр Монголын үйлдвэрлэгчид дараах стандартуудыг хангахад хүндрэлтэй байдаг. НАССР (Хүнсний аюулгүй байдлын удирдлага), ISO 22000, OIE/WOAH малын эрүүл мэндийн стандарт, Codex Alimentarius стандартууд, БНХАУ, ЕХ болон бусад улсын импортын тусгай шаардлага. Ялангуяа малын гарал үүсэл, эрүүл мэндийн түүх, боловсруулалтын үе шат бүрийн бүртгэл дутмаг байгаа нь өндөр үнэтэй зах зээлд нэвтрэх боломжийг бууруулдаг. <https://www.fao.org/mongolia/resources/publications/en>

Тээвэр, логистикийн хүндрэлийн хувьд далайд гарцгүй байршил, экспортын бүтээгдэхүүн урт зайд тээвэрлэгддэг, хөргөлттэй агуулах, хүйтэн хэлхээ (cold chain) хүрэлцээгүй, хилийн нэвтрэх хугацаа урт, БНХАУ-ын зах зээлээс өндөр хамааралтай зэрэг хүчин зүйл нь мах, сүү, жимс жимсгэнэ зэрэг түргэн муудах бүтээгдэхүүний экспортын эрсдэлийг нэмэгдүүлдэг.

Дэлхийн Банкны LAMP болон Livestock Commercialization төслүүдийн үнэлгээнд Мал эмнэлгийн үйлчилгээний чанар, нийлүүлэлтийн сүлжээний уялдаа, зах зээлийн хүртээмж, экспортын чанарын стандарт нь Монголын экспортын өрсөлдөх чадварыг тодорхойлох гол хүчин зүйл гэж үзсэн. <https://www.worldbank.org/en/results/2020/11/30/bringing-herders-closer-to-markets-and-livestock-services>

Мөн Дэлхийн банкны хэрэгжүүлж буй “Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх” төслийн тайлангуудыг <https://lcp.mn/page/detail/9> энэ линкээр орж танилцах боломтой. Тус төслийн хүрээнд Мах, сүүн бүтээгдэхүүний аюулгүй байдлын талаар хийгдсэн тайланг https://drive.google.com/file/d/1zqA_ex8ZTG9dk40W1zGq0mTPCX7u_bIA/view линкээр орж танилцна уу.

НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага (FAO) Монгол дахь мал эмнэлгийн тогтолцоог олон улсын стандартад нийцүүлэх, хүнсний аюулгүй байдлыг сайжруулах нь

мал аж ахуйн бүтээгдэхүүний экспорт нэмэгдэх үндсэн нөхцөл гэж дүгнэсэн. <https://www.fao.org/mongolia/resources/publications/en>

Азийн Хөгжлийн Банк (ADB)-ны Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй, тогтвортой мал аж ахуйн хөгжөл төслийн үнэлгээнд Малын эрүүл мэнд, бэлчээрийн тогтвортой ашиглалт, өртгийн сүлжээний шинэчлэл, экспортын чанар, өрсөлдөх чадвар сайжрахгүй бол тус салбарын экспортын өсөлт хязгаарлагдана гэж дурдсан. <https://www.adb.org/sites/default/files/linked-documents/53038-001-ea.pdf>

Монголын хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний экспортын хөгжлийг хязгаарлаж буй үндсэн асуудлууд нь:

- Малын халдварт өвчний эрсдэл, хорио цээрийн шаардлага.
- Олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх лабораторийн чадавхын хязгаарлалт.
- НАССР, ISO болон импортлогч орны стандарт хангах хүндрэл.
- Гарал үүслийн бүртгэл, мөрдөн мөшгөх системийн сул хөгжил.
- Тээвэр, логистик, хил дамнасан нийлүүлэлтийн өндөр зардал.

Эдгээр асуудлыг шийдвэрлэх нь мах, сүү, ноос ноолуур, арьс шир зэрэг бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх гол нөхцөл гэж дотоод болон олон улсын судалгаанууд дүгнэжээ.

Асуулт-4: Экспортын зөвшөөрөл, квот олголтод тавигдах шалгуур, хариуцах байгууллага

Экспортын зөвшөөрөл, квот олголтын хувьд:

Хүнсний тухай хуулийн 3.1.6-д заасан "стратегийн хүнс" гэж монгол хүний физиологийн хэрэгцээнд зайлшгүй шаардлагатай малын мах, сүү, тарианы үр, улаан буудай, гурил, ундны усыг; гэж заасан. Дотоодын хүнсний хангамж, аюулгүй байдлын бодлоготой уялдуулан Хүнсний тухай хуулийн 6.7-д зааснаар тухайн жилд экспортлох стратегийн хүнсний нэр төрөл, тоо хэмжээг хүнсний эрэлт, нийлүүлэлтэд тулгуурлан Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөлөөр хэлэлцэж, тус зөвлөлөөс гаргасан зөвлөмжид үндэслэн хуулийн 6.8-д экспортлох зөвшөөрлийг хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгодог.

Энэ харилцааг Хүнсний тухай хуулийн 5¹ дүгээр зүйлд заасан "Стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрөл олгох журам"-аар зохицуулдаг.

Монгол Улсын мал тоо толгой, үйлдвэрийн хүчин чадал, экспортыг нэмэгдүүлэх бодлоготой уялдуулан 2023 оноос хойш махны экспортын тоо хэмжээнд "тоо хэмжээний хязгаарлалт" тогтоохгүй байхаар тухайн бүр Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөл шийдвэрлэж ирсэн.

Мах экспортлогч аж ахуйн нэгжүүд хүнсний аюулгүй байдлын нийтлэг шаардлагыг хангах ёстой. Тухайлбал мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл нь өндөр эрсдэлтэй ангилалд ордог тул үйл ажиллагаа шинээр эхлэхэд хяналтын байгууллага урьдчилсан хяналт шалгалт хийж дүгнэлт гаргадаг. Мөн хүнсний зориулалтаар бэлтгэх мал, амьтан эрүүл байх, үйлдвэрлэлд эрүүл ахуй, үйлдвэрлэлийн зохистой дадал нэвтрүүлсэн байх, бүтээгдэхүүний уял мөрийг мөрдөн тогтоох бүртгэл хөтлөх зэрэг үүрэг хүлээнэ. Иймээс махны экспортын

зөвшөөрөл авах шалгуур нь зөвхөн квотын хүрээний сонгон шалгаруулалтаар хязгаарлагдахгүй, харин үйлдвэрлэл, аюулгүй байдал, гарал үүсэл, хяналтын тогтолцоог хамардаг.

Монгол Улс сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодоос бүрэн хангадаггүй тул Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөлөөс экспортын тоо хэмжээ тогтоодоггүй, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас экспортын зөвшөөрөл олгодоггүй болно. Харин хүн амын сүүн бүтээгдэхүүний хэрэгцээний тодорхой хувийг импортын хуурай сүүтээр үйлдвэрлэж байна.

Экспортын зөвшөөрөл, тавигдах шалгуур, хариуцах байгууллагын хувьд:

Мал эмнэлгийн ерөнхий газраас "Олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ" гэж экспортлогдож буй мал, амьтан, түүний гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн нь олон улсын гэрээ болон дотоодын хууль тогтоомжид заасан тодорхой нөхцөл шаардлагыг хангаж байгааг гэрчлэн олгодог.

Ургамал хамгааллын газраас "Амьтан, ургамал тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт шалгалтын тухай", "Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай", "Хүнсний тухай", "Байгалийн ургамлын тухай", "Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын тухай" хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг үндэслэн "Ургамлын хорио цээрийн гэрчилгээ", "импортын мэдэгдэл", "дамжуулан тээвэрлэх мэдэгдэл"-ийг олгож байна.

(Гадаад худалдааны үйл ажиллагаанд шаардаж буй баримт бичиг, иргэн, хуулийн этгээдийн бүрдүүлэх мэдээллийн жагсаалтыг хүснэгт 6-д харуулав.)

Асуулт-5: Малчид, хоршоод, үндэсний үйлдвэрлэгчдийг экспортын сүлжсээнд бодитоор оролцуулах, экспортын бүтээгдэхүүний боловсруулалтын түвшин, экспортын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, шинэ зах зээл нээх чиглэлээр Засгийн газраас хэрэгжүүлж буй бодлого, эрх зүйн шинэчлэлт болон санхүүжилт, зээл, дэмжлэгийн үр дүнгийн талаар;

Засгийн газраас хэрэгжүүлж буй бодлогын хувьд:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлан хэрэгжүүлж буй "Хүнсний хувьсгал", "Цагаан алт" үндэсний хөдөлгөөнүүд, түүнчлэн Засгийн газраас хэрэгжүүлж буй "Атар-IV", "Шинэ хоршоо – Чинээлэг малчин" хөтөлбөрүүдийн хүрээнд хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл, бүтээмж, экспортын чадавх тасралтгүй нэмэгдэж байна. Энэ нь хүнсний хангамж, аюулгүй байдлыг бэхжүүлэхийн зэрэгцээ хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний нэмүү өртгийг өсгөх, экспортыг төрөлжүүлэх, олон улсын зах зээлд өрсөлдөх чадварыг сайжруулах шинэ боломжуудыг бүрдүүлж байна.

- "Хүнсний хувьсгал" үндэсний хөдөлгөөний хүрээнд 2 жилийн хугацаанд 3160 иргэн, аж ахуйн нэгжид 1.2 их наяд төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгосноор сүү боловсруулах 10, мал төхөөрөх, мах боловсруулах 18, гурилан бүтээгдэхүүний 12, бусад нэр төрлийн бүтээгдэхүүний 13, нийт 53 үйлдвэр шинээр байгуулагдаж, газар тариалангийн зоорины багтаамж 15%, үтрэмийн багтаамж 7%, тариалангийн

талбай 13%, зуны болон өвлийн хүлэмж 28%-иар тус тус нэмэгдсэн. Мөн хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл 37%, ажлын байр 21%, дундаж борлуулалтын орлого 31%, дундаж цэвэр ашиг 32%, үндсэн хөрөнгө 55%, эргэлтийн хөрөнгө 38%, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар 46%, нийгмийн даатгал 60%-иар тус тус өссөн дүнтэй байна.

- “Цагаан алт” үндэсний хөдөлгөөний хүрээнд 2025 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар ноос ноолуур, арьс шир боловсруулах үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг дэмжих зорилгоор үйлдвэр аж ахуйн нэгжийн хүсэлтийг хүлээн авч эргэлтийн хөрөнгийн 382.4 тэрбум төгрөгийн 120 хяналтын гэрээ, хөрөнгө оруулалтын зээлийн 126.6 тэрбум төгрөгийн 62 хяналтын гэрээ, нийт 508.9 тэрбум төгрөгийн 182 зээлийн хяналтын гэрээг байгуулаад байна. 2026 онд ноос, ноолуур, арьс ширний бэлтгэл, үйлдвэрлэл, экспортыг дэмжсэн эргэлтийн хөрөнгийн зээл, зээлийн хүүгийн дэмжлэг үзүүлэх хүрээнд 86.3 тэрбум төгрөгийн төсөв батлагдсан. Ноолуурын үйлдвэрлэлийн салбарт 6,000 тн ноолуур бэлтгэсэн нь анх удаа түүхий эдийн 70 орчим хувийг дотоодын үйлдвэрлэгч нар бэлтгэсэн үзүүлэлт болж байна. Мөн ээрэх хүчин чадлыг 400.0 тн, сүлжих хүчин чадлыг 200 мянган ширхэгээр нэмэгдүүлэх боломж бүрдүүлээд байна. Ноосны үйлдвэрлэлийн салбарт эргэлийн хөрөнгийн зориулалтаар 35.0 тэрбум төгрөгийн зээл олгогдож, 20,000 тн ноос бэлтгэхээр төлөвлөж байна. Арьс ширний үйлдвэрлэлийн салбарт эргэлийн хөрөнгийн зориулалтаар 25.1 тэрбум төгрөгийн зээл олгогдож, 1.2 сая ширхэг бог, 488.5 мянган ширхэг бодын шир бэлтгэх нөхцөл бүрдлээ.
- Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 47 дугаар тогтоолоор баталсан “АТРЫН IV АЯН” тариалангийн салбарын дунд хугацааны бодлогын хүрээнд хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжин хөнгөлөлттэй зээлийг олгож байна. Нийт 939 зээлдэгч, 616.5 тэрбум төгрөгийн зээлийг олгохоор шийдвэрлэсэн бөгөөд зээл олголтын дүнг салбараар ангилахад 215.8 тэрбум төгрөгийг газар тариалангийн чиглэлээр, 106.9 тэрбум төгрөгийг мал аж ахуй, 293.7 тэрбум төгрөгийг хүнсний үйлдвэрийн чиглэлээр тус тус олгоод байна. “АТРЫН IV АЯН”-ы хүрээнд төмс, хүнсний ногооны агуулахын багтаамж 17000 тонноор, анхан шатны үр үржүүлгийн төв үтрэмийн багтаамж 15000 тонноор тус тус нэмэгдүүлснээр 2025 оны байдлаар төмс, хүнсний ногооны зоорийн нийлбэр багтаамж 305 мянган тонн, үр тарианы үтрэмийн нийлбэр багтаамж 347 мянган тоннд хүрлээ. Атар-4 тариалангийн тогтвортой хөгжлийн аяны хүрээнд мал аж ахуйн хөгжлийг дэмжих, үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор “Нутагтаа эзэн 100:1000” төслийг 17 аймгийн 25 суманд хэрэгжүүлж Улсын төсвийн 986.0 сая төгрөгийн санхүүжилтээр 3 төрлийн тэжээлийн таримлын 412 тонн үрийг олгосоноор таримал тэжээлийн тариалалт 2300 га-аар нэмэгдэж байна.
- “Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж байгаа уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай” хуулиар эрх олгогдсоны дагуу Засгийн газрын 2024 оны “шинэ хоршоо хөдөлгөөн” өрнүүлэх тухай 166 дугаар тогтоолын хавсралтаар шинэ хоршоо-чинээлэг малчин арга хэмжээний төлөвлөгөөг баталсан. Уг төлөвлөгөөнд хоршооны гишүүн малчинд хөрөнгө оруулалтын зориулалтаар хөнгөлөлттэй зээл олгож, зээлийн хүүгийн зөрүүг Засгийн газраас хариуцан төлөх талаар тодорхой тусгасан. Ингэснээр хоршооны гишүүн малчинд 50 хүртэл сая төгрөгний жилийн 18 хувийн хүүтэй зээлийг 5 жилийн хугацаатайгаар олгох боломж бүрдсэн. Энэхүү зээлийн хүүгээс 6 хувийг зээлдэгч малчин, үлдсэн

12 хувийн хүүг Монгол Улсын Засгийн газар хариуцан төлөх байдлаар арилжааны банкууд хооронд байгуулсан 2025 оны 5 дугаар сарын 07-ны өдрийн 240509/84, 240508/03-372, 1824/A73 дугаартай “Хоршооны гишүүн малчны зээл”-ийн санхүүжилтийн “Ерөнхий гэрээ”-ний дагуу арилжааны банкуудаар зээл олгосон.

/2025 оны 12 дугаар сарын 31-ны байдлаар/

Хоршооны гишүүн малчны зээл	Зээлийн хэмжээ /тэрбум төгрөг/	Хоршооны тоо	Зээл авсан малчны тоо
2024-2025	866.3	7619	25569

Жижиг, дунд үйлдвэрийн газраас 21 аймагт Шинэ хоршоо хөдөлгөөнөөс олгосон зээлийн зориулалтын үр дүнд хийсэн судалгаагаар нийт зээлийн 38 хувийг үржлийн мал худалдан авах, бойжуулах, борлуулах, 32 хувийг сүү, цагаан идээ боловсруулах, 30 хувийг бусад зориулалтаар зарцуулсан үзүүлэлтэй байна.

Шинээр 1160 ажлын байр бий болгож, зээлийн үр дүнд малын үүлдэрлэг байдал 57.7-63.9 хувь, өвс тэжээл бэлтгэлийн хүрэлцээ 34.6-37.9 хувь, малын хашаа, саравчийн хүрэлцээ 31.3-34.5 хувь, тоног төхөөрөмжийн хангалт 19.6-23.2 хувь, МАА-н үйлдвэрлэлийн мэдлэг 15.3-19.7 хувь, ажиллах хүчний хангамж 9.8-11.6 хувь, малын тэжээл тариалах газрын хүртээмж 9.7-9.9 хувиар өссөн байна.

2026 оны 06 сарын байдлаар 136,44 тэрбум төгрөгийн зээлийн эргэн төлөлттэй байна.

Малчдын зээлийн багцын чанар харьцангуй сайн түвшинд байна. Нийт зээлийн 96.3 хувь нь хэвийн ангилалд багтаж байгаа бөгөөд чанаргүй зээлийн хэмжээ ердөө 1.8 хувийг эзэлж байна. Энэ нь малчид зээлийн эргэн төлөлтийн сахилга бат сайн, санхүүгийн үүргээ тогтмол биелүүлдэг зээлдэгчдийн бүлэг болохыг харуулж байна. Түүнчлэн нийт зээлийн 90.8 хувь нь 1-5 жилийн хугацаатай байгаа нь мал аж ахуйн үйлдвэрлэлийн онцлогт нийцсэн санхүүжилтийн бүтэц бүрдсэнийг илэрхийлж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 380 дугаар тогтоолоор “Ямааны ноолуурын боловсруулалт, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалт”-ыг баталсан. Уг техникийн зохицуулалтын зорилго нь ямааны ноолуурын боловсруулалт, худалдааны явцад хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчны аюулгүй байдлыг хангах, нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүний эзлэх хувийг нэмэгдүүлэх, техникийн зохицуулалтын шаардлага хангаагүй бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэхээс хамгаалахад оршино. Уг техникийн зохицуулалт хэрэгжсэний үр дүнд самнасан ноолуурын экспортын хэмжээ 2025 онд 4.0 мянган тонн болж, өмнөх оноос 3.3 (5.7 дахин) мянган тонноор, үнийн дүн 332.5 сая ам.доллар болж, 262.6 (4.8 дахин) сая ам.доллаар тус тус өсжээ.

Жижиг, дунд, үйлдвэрийн газраас үндэсний үйлдвэрлэгчдийг олон улсын зах зээлд нэвтрүүлэх, экспортын суваг бий болгох зорилгоор томоохон орнуудад жил бүр үзэсгэлэн арга хэмжээг зохион байгуулж оролцуулан хамтран ажилладаг. Гадаад улсад зохион байгуулсан арга хэмжээ 2026 оны хувьд:

- БНСУ-д 2026 оны 03 дугаар сарын 14-17-ны өдрүүдэд 14 аж ахуй нэгжийн 40 гаруй төрлийн бүтээгдэхүүнээр оролцож ойролцоогоор 141.7 сая төгрөгийн бүтээгдэхүүн борлуулсан.
- Япон улсын нийслэл Токио хотын “Tokyo Big Sight” үзэсгэлэнд 2026 оны 03 дугаар сарын 10-13-ны өдрүүдэд 8 аж ахуй нэгжийг оролцуулан хамтран ажилласан.

- Лондон хотод “Монголын тэмээний өдөрлөг” арга хэмжээг 2026 оны 04 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулж 12 аж ахуй нэгж оролцож 66.5 сая төгрөгийн борлуулт хийсэн.

Дотоодод жил бүр үзэсгэлэн арга хэмжээг зохион байгуулж ажиллаж байна. 2026 оны хувьд:

- “Амар байна уу 2026” нэртэй цогц үзэсгэлэн, худалдаа, хөрөнгө оруулалт, хамтын ажиллагааны арга хэмжээг амжилттай зохион байгууллаа. Тус арга хэмжээ “Их наяд” болон “Соёолж молл” худалдааны төвд нэг сарын турш үргэлжилж, нийслэлийн есөн дүүрэг болон 21 аймгийн ойролцоогоор 1,000 орчим жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч түрээсийн ямар нэгэн төлбөргүй оролцож, 55,000 нэр төрлийн бараа, бүтээгдэхүүнийг үйлдвэрийн үнээр сурталчлан борлуулсан юм. Үзэсгэлэнгийн үр дүнд 52.5 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой ажилласан.
- “FEEL MONGOLIA 2026” арга хэмжээг 2026.03.27-28-ны өдрүүдэд One Event Hall Mongolia-д Эдийн засаг, Хөгжлийн яам, Жижиг, дунд үйлдвэрийн газар, Нийслэлийн аялал жуулчлалын газар, Монголын аялал жуулчлалын холбоо хамтран зохион байгуулав. Тус арга хэмжээнд 150 гаруй ААН байгууллага, үндэсний үйлдвэрлэгч, жуулчны бааз, ресорт, технологийн шинэ шийдэл, аяллын сонирхолтой бүтээгдэхүүн үйлчилгээг нэг дор танилцуулна. Нийт оролцогчдын 60 гаруй хувь нь жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчид байна.
- 2026 оны 01 дүгээр сарын 26-аас 2 дугаар сарын 17-ны өдрүүдэд “Баянголд үйлдвэрлэв” нэрийн барааны төв дэлгүүрт зохион байгуулсан “Баян гоё – Цагаан сар 2026” үзэсгэлэн арга хэмжээг “Баянгол үйлдвэрлэв” нэрийн барааны дэлгүүртэй хамтран зохион байгуулав. Үзэсгэлэн худалдаанд 60 үндэсний үйлдвэрлэгч хамрагдаж 148,700,000 төгрөгийн борлуулалттай ажиллав.
- Япон-Монголын худалдааны танхимаас 5 дахь удаагаа зохион байгуулж буй “GOLDEN WEEK-2026” Монгол-Японы бизнес өдөрлөгийг хамтран зохион байгуулж байна. 2026 оны 6 дугаар сарын 5,6,7-ны өдрүүдэд зохиогдох уг өдөрлөгт Монгол-Япон хоёр орны хооронд бизнес эрхэлдэг аж ахуй нэгжүүд, мөн дотоодын үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч нийт 40 байгууллага 50 асарт бүтээгдэхүүн үйлчилгээгээ дэлгэн оролцов. Нийт 210,000,000 төгрөгийн борлуулалтын орлого олсон.
- “ДЭЛХИЙН ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРИЙН ӨДӨР-2026” үзэсгэлэн худалдаа 5 дахь удаагаа 2026.06.12-14-ны өдрүүдэд Д.Сүхбаатарын нэрэмжит талбайд зохион байгуулж 400 гаруй бизнес эрхлэгчид, 1000 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүнээр оролцож 1,2 тэрбум төгрөгийн борлуулалтын орлого олов. Мөн ОХУ, Вьетнам, Япон, Энэтхэг, Англи, Итали улсын бүтээгдэхүүн үйлдвэрлэгч оролцсоноороо онцлог байв.

Мөн Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын экспорт, импортын хүнсний аюулгүй байдлын хамтын ажиллагааны Дэд сайд нарын түвшний VI уулзалт БНХАУ-ын Шямэнь хотноо 2026 оны 06 дугаар сарын 24-ны өдөр зохион байгуулагдсан. Уулзалтаар хоёр тал экспорт, импортын хүнсний аюулгүй байдал, мал, амьтны эрүүл мэнд, ургамлын хорио цээрийн чиглэлээр хэрэгжүүлж буй хамтын ажиллагааны явцыг дүгнэж, худалдааг хөнгөвчлөх, хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний экспортлох боломжийг нэмэгдүүлэх чиглэлээр цаашид хэрэгжүүлэх ажлуудын талаар тохиролцсон.

Мөн “Монгол Улсаас БНХАУ-д адууны мах экспортлох үеийн хяналт шалгалт, хорио цээр, ариун цэврийн шаардлагын тухай протокол”-ыг шинэчлэн байгуулж гарын үсэг зурсан ба ингэснээр малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний экспортын нэр төрлийг нэмэгдүүлж, БНХАУ-д адууны дайвар бүтээгдэхүүн экспортлох нөхцөл бүрдсэн.

Монгол Улс, Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнуудын хооронд Худалдааны түр хэлэлцээрийг байгуулсан нь хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл, худалдааг эрчимжүүлж Евразийн 180 сая гаруй хэрэглэгчтэй томоохон зах зээлд бараа бүтээгдэхүүнээ гаалийн тарифаас чөлөөлүүлж, илүү таатай нөхцөлөөр нийлүүлэх боломжийг олгож байгаа.

Ялангуяа мах, махан бүтээгдэхүүн, ноос, ноолуур, арьс шир, нэхмэл болон оёмол бүтээгдэхүүн зэрэг манай улсын өрсөлдөх давуу тал бүхий салбаруудын экспорт нэмэгдэх, үйлдвэрлэл өргөжих, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд үр дүнгээ өгнө гэж үзэж байна.

Хэлэлцээрийн хүрээнд Монгол Улсаас экспортлох 367 барааны 97.5 хувь нь хөдөө аж ахуйн гаралтай, хүнс, хөнгөн үйлдвэрийн бараа бүтээгдэхүүн байна. Харин ЕАЭЗХ-ноос манай улсад импортлох 367 барааны 81.7 хувь нь манай улсад үйлдвэрлэх боломж хязгаарлагдмал эрдэс, химийн, 7.5 хувь нь аж үйлдвэрийн салбарын бараа бүтээгдэхүүн байна. Уг жагсаалтанд улаанбуудай, өндөг, хуурай сүү зэрэг стратегийн хүнсийг бууруулсан татвартайгаар, тодорхой тоо хэмжээгээр импортлохоор тусгасан. Хэлэлцээрийг хэрэгжүүлэхдээ дотоодын үйлдвэрлэлийг хамгаалах, хангамжийн тогтвортой байдлаа хангах бодлого, арга хэмжээг хамтад нь авч хэрэгжүүлэх шаардлага бий.

Хэлэлцээр нь зөвхөн экспортын боломжийг нэмэгдүүлэхээс гадна хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн шинэчлэлд эерэг нөлөө үзүүлэх ач холбогдолтой. Үйлдвэрлэлд шаардлагатай тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл, сав баглаа боодлын материал, туслах түүхий эдийн нийлүүлэлтийн нөхцөл сайжирснаар аж ахуйн нэгжүүд технологийн шинэчлэл хийх, бүтээмжээ нэмэгдүүлэх, бүтээгдэхүүний чанараа сайжруулахад дэмжлэг болохоор байна.

Энэхүү хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах бэлтгэл ажлын хүрээнд Монгол Улс, Бүгд Найрамдах Беларус улсын Засгийн газар хоорондын комиссын 8 дугаар хуралдааны үеэр “Ургамал хамгаалал, хорио цээрийн салбарт хамтран ажиллах тухай” яам хоорондын санамж бичгийг Монгол Улсын Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам болон БНБУ-ын Хөдөө аж ахуй, хүнсний яамны хооронд байгуулсан. Энэхүү санамж бичгийг Армени, Киргиз улстай байгуулахаар бэлтгэл хангаж байна.

